



2023 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

"ЛэндМН ББСБ" ХК





lendmn

Асаа. Асуудлаа шийд

Агуулга

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2023 оны I улирлын
санхүү, үйл ажиллагааны тайлан

01

Онцлох
үйл явдлууд

02

Зээлийн үйл
ажиллагаа

03

Санхүүгийн
тайлагнал

04

Эрсдэлийн
удирдлага

05

Компанийн
засаглал

Онцлох үйл явдлууд

01

“ЛЭНДМН ББСБ” ХК 1.3 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХААР БОЛЛОО.

2022 онд “ЛэндМН ББСБ” ХК (MSE:LEND)-ийн зээлийн багц өмнөх жилийн эцсээс 2.1 дахин өсөж 71.1 тэрбум төгрөг, компанийн цэвэр ашиг 5.53 тэрбум төгрөгт хүрсэн байна.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 сарын 06-ны өдрийн хурлаас компанийн нэгж хувьцаанд 1.75 (нэг зууны далан тав) төгрөгийг ногдол ашиг тооцон олгохоор тогтоож, 2022 оны цэвэр ашгийн 23.4 (хорин гурав аравны дөрөв) хувийг буюу 1,293,778,000 (нэг тэрбум хоёр зуун ерэн гурван сая долоон зуун далан найман

мянга) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэлээ. Ногдол ашгийг 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгох юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 3-р сарын 24-ний өдрөөр тогтоолоо.

“ЛэндМН ББСБ” ХК
**1.3 тэрбум төгрөгийн
ногдол ашиг**
хуваарилахаар боллоо

ДИЖИТАЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ “ЛЭНДБОНД”-ЫН ӨГӨӨЖ ҮНЭТ ЦААСНЫ ДАНСАНД БАЙРШЛАА.

2021 оны 06-р сарын 30-ны өдөр арилжаалсан “ЛЭНДБОНД”-ын өгөөж болох 352.9 сая төгрөг 2023 оны 01-р сарын 02-ны өдөр үнэт цаасны дансанд байршлаа.

Харилцагч та “ЛЭНДБОНД”-ын өгөөжөө өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан авах боломжтой.

Хөрөнгө оруулагч та SuperUp аппликейшнээр “ЛЭНДБОНД” захиалан авсан бол Райнос Инвестмент ҮЦК-ийн 7510-0575 дугаарт хандан дэлгэрэнгүй мэдээлэл авч өөрийн үнэт цаасны мэдээллийг аваарай.

#ДижиталХөрөнгөОруулалт #ЛэндБонд
#СанхүүгээЗөвУдирддагХүнБүртЗориулав



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ 2023.04.15-НЫ ӨДӨР БОЛНО.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 6 дахь удаагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Корпорейт Хотел энд Конвейшн Центр “Эвэнт” танхимд 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 12 цагт зохион байгуулагдана.

Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа идэвхтэй оролцохыг уриалж байна.



БИД МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ISO/IEC 27001:2013 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ШААРДЛАГЫГ ХАНГАН АЖИЛЛАЖ БАЙНА.

“ЛэндМН ББСБ” ХК нь 2022 онд “МонСертф” ХХК-аар баталгаажуулалтын аудит хийлгэж, Мэдээллийн Аюулгүй Байдлын Менежментийн Тогтолцооны ISO/IEC 27001:2013 олон улсын стандартын шаардлагыг ханган ажиллаж байна.

2023.03.21-ний өдөр “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр, Мэдээлэл технологийн албаны менежер Э.Эрэлхэгзориг нар олон улсын сертификатаа албан ёсоор Энэтхэг улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд, ноён П.М.Сингхаас гардан авлаа.

ЛэндМН-ийн Мэдээллийн аюулгүй байдал менежментийн тогтолцоо нь олон улсын стандартад нийцсэнээр харилцагчдын мэдээллийн нууцлал, түүний хадгалалт, аюулгүй байдал нь найдвартай хамгаалагдах ач холбогдолтой юм.

Биднийг үргэлж дэмжин ажилладаг харилцагч, хамтран ажиллагч байгууллагууддаа баярлалаа.



ЦАХИМ СПОРТЫГ ДЭМЖИН АЖИЛЛАЛАА.


Цахим спортын CS:GO төрлийн хамгийн том тэмцээн болох дэлхийн аварга шалгаруулах энэ оны эхний MAJOR тэмцээн нь Франц улсын нийслэл Парис хотод 2023 оны 5-р сарын 8-аас 5-р сарын 21-ний хооронд зохион байгуулагдах гэж байгаа билээ.

Уг тэмцээнд Ази тивийн төлөөллийг сонгон шалгаруулах Asia-Pacific RMR

тэмцээн нь 2-р сарын 15-аас 4-р сарын 12-ны хооронд зохион байгуулагдаж байна.

Энэхүү тэмцээний эргэн тойрны хүрээнд болж буй сонирхолтой, ерөнхий мэдээллүүдийг нэгтгэн хүргэдэг RMR Talk-ийн 5 дугаарыг дэмжин ажиллаж байна.

E sport-ийг дэмжигч #LendMN



ШИНЭ МОНГОЛ СУРГУУЛИЙН СУРАГЧИД ЛЭНДМН-ЭЭР ЗОЧИЛОО.

Шинэ Монгол сургуулийн 10 дугаар ангийн сурагчид ЛэндМН-ээр зочилж, ЛэндМН-ийн үйл ажиллагаатай танилцлаа.

Сурагчид өөрсдийн сонирхож буй мэргэжлийнхээ дагуу ажлын байран дээр ирж, хүссэн ажил мэргэжил бүрийнхээ онцлогуудыг тодруулж, нээлттэйгээр харилцан ярилцаж, ажил үүргийн талаар, едер тутмын үйл ажиллагааны тухай бодит нөхцөл байдалтай танилцаж, цаашдын

мэргэжил сонголтоо хийхэд шаардлагатай бяцхан судалгааг хийцгээсэн юм.

Бидний ажлын байртай танилцаж, мэдээлэл зөвлөгөө авахаар ирсэн сурагч дүү нартаа цаашдын хичээл сурлагад нь болон ирээдүйн их ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье.

Ирээдүйн мэргэжил сонголт нь мэргэн байх болтугай.



Зээлийн үйл ажиллагаа

02



ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 13 ажилтантайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2023 оны I улирлын турш нийт 119,639 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад

үйлчилгээний талаар харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 96.67%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.



2023 оны I улиралд хүлээн авсан

91,527

нийт дуудлага

13 секунд

хүлээлгийн түвшин

Үйлчилгээ

96.67%

амжилттай хүргэсэн

Сошиал суваг болон

28,112

үйлчилгээний заалаар үйлчилсэн


ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2023 оны I улиралд LendMN аппликейшнээр дамжуулан харилцагч нартаа нийт 219.0 тэрбум төгрөгийн дүнтэй 838.8 мянган зээлийг олгосон байна. 2023 оны I улирлын зээлийн голлох

үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 5.7%, олгосон зээлийн тоо 70.6%, зээлийн багц 118.9%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Гэрээт харилцагчийн тоо

/Өссөн дүнгээр, мянган харилцагчид/




Зээлийн багц

/Тэрбум төгрөг/




Нийт олгосон зээлийн дүн

/Тэрбум төгрөг/



Нийт олгосон зээлийн тоо

/Мянган зээл/




Санхүүгийн тайлагнал

03

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2023 оны I улирлын байдлаар компанийн хүүгийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 155.0%-иар өсч 9.7

тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашиг 3.7 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеээс 292.5%- иар өссөн байна.



Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2023 оны I улирлын байдлаар чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 4.5% байгаа бөгөөд энэ улиралд зээлийн эрсдэлийн

сангийн нөөц 4.0 тэрбум төгрөг буюу зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ 114.8% байна.



Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Тэрбум төгрөг/	2022.III /Аудитлагдаагүй/	2022.IV /Аудитлагдаагүй/	2023.I /Аудитлагдаагүй/
Нийт орлого	4.9	7.5	9.7
Хүүгийн зардал	(1.2)	(1.8)	(2.2)
Цэвэр орлого	3.7	5.7	7.5
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(0.9)	(1.1)	(1.3)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(0.4)	(0.2)	(0.7)
Үйл ажиллагааны цэвэр орлого	2.4	4.4	5.5
Удирдлагын болон ҮА-ны зардал	(0.9)	(1.2)	(0.9)
Татварын өмнөх ашиг	1.5	3.2	4.6
Татварын зардал	(0.2)	(0.6)	(0.9)
Цэвэр ашиг	1.3	2.6	3.7

Санхүү байдлын хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2022.III /Аудитлагдаагүй/	2022.IV /Аудитлагдаагүй/	2023.I /Аудитлагдаагүй/
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	2.3	5.9	4.3
Зээлийн багц (цэвэр)	46.3	67.7	73.7
Бусад хөрөнгө	2.3	2.4	2.6
Үндсэн хөрөнгө	0.7	0.6	0.5
Биет бус хөрөнгө	0.4	0.4	0.4
Нийт хөрөнгө	52.0	77.0	81.5

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/	2022.III /Аудитлагдаагүй/	2022.IV /Аудитлагдаагүй/	2023.I /Аудитлагдаагүй/
Өр төлбөр	27.5	49.9	50.8
Эх үүсвэр	24.6	40.6	40.8
Бусад өглөг	2.9	9.3	10.0
Эздийн өмчийн дүн	24.5	27.1	30.7
Хувьцаат капитал	8.5	8.5	8.5
Хоёрдогч өглөг	2.8	2.8	2.8
Хуримтлагдсан ашиг	13.2	15.8	19.4
Нийт өр төлбөр болон эздийн өмч	52.0	77.0	81.5

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“ЛэндМН ББСБ” ХК нь тайлант хугацаанд гадаад болон дотоод орчны эрсдэлийг дахин шинэчлэн үнэлж алба нэгжүүддээ эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж өгч, холбогдох журам заавраар хангахын сацуу дотоод хяналтыг хэрэгжүүлэн Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороонд тайлагнан, шаардлагатай мэдээллээр хангаж ажилласнаар Эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх, засаглалыг тасралтгүй сайжруулах үндсэн зорилгыг хэрэгжүүлсэн байна.

Зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, мэдэгдэл, журмын шинэчлэлийг цаг алдалгүй үйл ажиллагаандаа нийцүүлэн ажиллах зарчмын хүрээнд холбогдох журмуудыг дотоод үйл ажиллагаа болон хуулийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж, үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2023 оны I-р улирлын байдлаар 2.2 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 4.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Дээрх 4.0 тэрбум төгрөг нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 114.8%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд 2023 оны I-р улирлын байдлаар зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2022.III	2022.IV	2023.I
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	38.1%	28.1%	29.8%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	43.1%	31.5%	32.8%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	41.7%	31.5%	34.1%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	8.5%	12.0%	8.6%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	(19.7%)	(39.8%)	(38.1%)
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	45.8%	78.5%	71.6%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	42.4%	38.0%	33.8%

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) нь компанийн сайн засаглалын тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж хувьцаа эзэмшигчдэдээ урт хугацааны үнэ цэнийг бий болгох, Компанид итгэх итгэлийг бэхжүүлэн ажиллахыг эрмэлздэг билээ. Түүнчлэн, Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж

мөрдөх, ил тод байдлыг хангах, нээлттэй тайлагналыг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг дотоод журмаар нарийн нягт зохицуулах зэрэг зарчмуудыг баримталж, сайн засаглалын хэм хэмжээ, стандартыг бүрдүүлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) 2023 оны I улиралд ээлжит 1, ээлжит бус 3 удаа хуралдан Компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг тухай бүр шийдвэрлэн ажилласан байна. ТУЗ-ийн шийдвэрлэсэн асуудлуудаас онцлон дурдвал:

- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Корпорейт Хотел энд Конвейшн Центрын эвэнт танхимд зохион байгуулахаар шийдвэрлэж, хурлаар хэлэлцэх асуудал, хурал зохион байгуулах болон тооллогын комиссын бүрэлдэхүүн зэргийг батлав.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Компанийн ТУЗ нь эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий **1) Аудитын хороо, 2) Эрсдэлийн удирдлагын хороо, 3) Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороодтой** бөгөөд тус хороод нь 2023 оны I улиралд тус бүрийн чиг үүрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, Компанийн үйл ажиллагаанд шаардлагатай дүгнэлт, санал гарган ажиллалаа. ТУЗ-ийн дэргэдэх хороодын хэлэлцэж, дүгнэлт гаргасан асуудлуудаас онцлон дурдвал:

Аудитын хороо

- 2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж, Компанийн Хувьцаа

- “Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК-аас Компанийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тасалбар болгон хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, тайланг хангалттай гэж дүгнэсэн ба тус дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулан шийдвэрлүүлэхээр тогтов.
- Компанийн 2022 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн 23.4 (хорин гурав аравны дөрөв) хувийг буюу 1,293,778,000 (нэг тэрбум хоёр зуун ерэн гурван сая долоон зуун далан найман мянга) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэв.

эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх тухай дүгнэлт гарган ТУЗ-д хүргүүлэв.

Эрсдэлийн удирдлагын хороо

- Компанийн эрсдэлийн тайлан;
- Эх үүсвэрийн тайлан зэрэг асуудалтай танилцаж, Компанийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа талаар ТУЗ-ийн хуралд танилцуулав.

Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

- Гүйцэтгэх захирлын саналыг үндэслэн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь улируулан сонгох эсэх;
- ТУЗ-ийн 2023 оны төсвийн саналыг батлах эсэх зэрэг асуудлыг хэлэлцэж, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх дүгнэлт гарган ТУЗ-д хүргүүлэв.



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn

2023 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайланг бэлтгэсэн:
Маркетингийн албаны менежер Б.Батбилэг
Хянасан: Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр